



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ
СУРГУУЛИЙН ХАРЬЯА
ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/47

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 13.1.6, 13.3.5 дахь заалтууд, Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйл, Дээд боловсролын тухай хуулийн 17.3 дахь заалт, ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн дүрмийн 4.10.3, 4.10.8, 4.10.14, 4.10.15 дахь заалтууд, ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн захирлын зөвлөлийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ШУТИС-ийн харьяа технологийн коллежийн "Багш, ажилтны нийгмийн баталгааг хангахтай холбоотой харилцааг зохицуулах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмыг мөрдөж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалыг 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй

ЗАХИРАЛ



Д.ДУЛМАА

Технологийн коллежийн Захирлын дүгээр тушаал

1

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Захирлын 20 ²⁶ оны
..06. дугаар сарын .05. -ны өдрийн ... дүгээр тушаалын хавсралт



АГУУЛГА

АГУУЛГА	2
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
НЭГ. ХАМРАХ ХҮРЭЭ	3
ХОЁР. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ	3
ГУРАВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ	3
ДӨРӨВ. ТЭТГЭМЖ ОЛГОХ	3
ТАВ. БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ОЛГОХ	4
ЗУРГАА. СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ	5
ДОЛОО. САНХҮҮЖИЛТ	5
НАЙМ. БУСАД	5

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Захирлын 2026 оны
..06 дугаар сарын ..06-ны өдрийн 1/17 дүгээр тушаалын хавсралт



НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү журмаар ШУТИС-ийн харьяа Технологийн коллеж (цаашид сургууль гэх)-ийн багш, ажилтанд тэтгэмж, буцалтгүй тусламж, сургалтын төлбөрийн хөнгөлөлт олгохтой холбоотой харилцааг зохицуулна.

НЭГ. ХАМРАХ ХҮРЭЭ

- 1.1 ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн нийт багш, ажилтан.

ХОЁР. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- 2.1. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль.
2.2. ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Хөдөлмөрийн дотоод журам.

ГУРАВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 3.1. Багш гэж хөдөлмөр эрхлэлтийн харилцааны үндсэн дээр байгууллагатай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж буй тэнхимийн эрхлэгч, ахлах багш, багш, дадлагажигч багшийг;
3.2. Ажилтан гэж хөдөлмөр эрхлэлтийн харилцааны үндсэн дээр байгууллагатай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж буй удирдах, гүйцэтгэх, үйлчилгээний ажилтныг;
3.3. Хүүхэд гэж тухайн багш, ажилтны төрсөн болон хууль ёсны асрамжинд байгаа хүүхдийг;
3.4. Тэтгэмж гэж багш, ажилтан нь Хөдөлмөрийн хуулийн заалтад үндэслэн өндөр насны тэтгэвэр тогтоолгон, байгууллагатай хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгоход, мөн дотоодын эмнэлэг сувилалд эмчлүүлэхэд олгох мөнгөн дүнг;
3.5. Буцалтгүй тусламж гэж одоо ажиллаж буй багш, ажилтан гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл (гал, усны үер, газар хөдлөл, салхи шуурга гэх мэт)-ийн улмаас хохирсон, осол болон хүнд өвчний улмаас эмчлүүлсэн, өөрөө эсвэл гэр бүлийн гишүүд нас барсан, мөн өндөр насны тэтгэвэрт гарсан багш, ажилтан нас барсан тохиодолд олгох мөнгөн дүнг тус тус хэлнэ.

ДӨРӨВ. ТЭТГЭМЖ ОЛГОХ

- 4.1. ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн багшийн мэргэжлийн талаарх ажлын байрны тодорхойлолтод тавигдсан шаардлагыг хангасан багш, ажилтанд дараах тохиолдолд нэг удаагийн тэтгэмж олгоно. Үүнд:
4.1.1. Багш, ажилтан нь Хөдөлмөрийн хуулийн 82.1 заалтад заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлахад;
4.1.2. Багш, ажилтан өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгоход нэг удаа тэтгэмж олгох ба тэтгэмжийн мөнгөн дүнг тооцохдоо дараах нөхцлийг харгалзана.
4.1.2.1. Багш, ажилтан нь ШУТИС болон ШУТИС-ийн харьяа Технологийн коллежид тасралтгүй ажилласан тохиолдолд Хүснэгт 1-д үзүүлсний дагуу багш, ажилтны ажилласан нийт хугацааг сараар багцлан илэрхийлж, тухайн багц сард оногдох мөнгөн дүнг ажилтны сарын үндсэн цалингаар жишин бодож олгоно.

Хүснэгт 1

№	ШУТИС-д ажилласан хугацаа (сараар)	Тэтгэмжийн мөнгөн дүн (үндсэн цалин)	№	ШУТИС-д ажилласан хугацаа (сараар)	Тэтгэмжийн мөнгөн дүн (үндсэн цалин)
---	------------------------------------	--------------------------------------	---	------------------------------------	--------------------------------------

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Захирлын 20 26 оны
..06 дугаар сарын ..05 -ны өдрийн 1/49 дүгээр тушаалын хавсралт

1	4-24	1 сарын цалин	10	217-228	10 сарын цалин
2	25-60	2 сарын цалин	11	229-240	11 сарын цалин
3	61-120	3 сарын цалин	12	241-252	12 сарын цалин
4	121-156	4 сарын цалин	13	253-264	13 сарын цалин
5	157-168	5 сарын цалин	14	265-276	14 сарын цалин
6	169-180	6 сарын цалин	15	277-288	15 сарын цалин
7	181-192	7 сарын цалин	16	289-300	16 сарын цалин
8	193-204	8 сарын цалин	17	301-312	17 сарын цалин
9	205-216	9 сарын цалин	18	313 ба түүнээс дээш	18 сарын цалин

4.1.2.2. Багш, ажилтан нь ШУТИС-аас бусад ШУТИС-аас бусад сургууль, боловсролын байгууллагад ажиллаж байгаад тус сургуульд шилжин ажилласан тохиолдолд Хүснэгт 2-т үзүүлсний дагуу багш, ажилтны боловсролын байгууллагад нийт хугацааг жилээр багцлан илэрхийлж, тухайн багц жилд оногдох тэтгэмжийн мөнгөн дүнг ажилтны сарын үндсэн цалингаар жишин бодож олгоно.

Хүснэгт 2

№	Боловсролын байгууллагад ажилласан хугацаа (жилээр)	Тэтгэмжийн мөнгөн дүн (үндсэн цалин)	№	Боловсролын байгууллагад ажилласан хугацаа (жилээр)	Тэтгэмжийн мөнгөн дүн (үндсэн цалин)
1	15-аас 18 жил	3 сарын цалин	3	21-аас 25 жил	9 сарын цалин
2	18-аас 21 жил	6 сарын цалин	4	25 ба түүнээс дээш	12 сарын цалин

4.1.3. Төрийн байгууллагад 20-оос доошгүй жил, үүнээс ШУТИС болон ШУТИС-ийн харьяа Технологийн коллежид 10-аас доошгүй жил ажилласан багш, ажилтанд ээлжийн амралтын хугацаандаа магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагын шийдвэрээр дотоодын сувилалд эмчлүүлэх тохиолдолд холбогдох баримт бичигт үндэслэн 300,000 хүртэл төгрөгийн тэтгэмжийг 3 жилд нэг удаа олгох асуудлыг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

4.1.4. Багш, ажилтан докторын зэргийн урьдчилсан хамгаалалтаа амжилттай хамгаалсан тохиолдолд 1.500.000 хүртэл төгрөгийг тэтгэмжийг нэг удаа олгоно.

- 4.2. Багш, ажилтан нь Хөдөлмөрийн хуульд заасан үндэслэлээр ШУТИС дотроо өөр ажлын байранд ажиллах болсон тохиолдолд тэтгэмж олгохгүй.
- 4.3. Багш, ажилтан нь "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хууль"-д заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгосон багш, ажилтанд тус журамд заасан нэг удаагийн тэтгэмж олгохгүй.
- 4.4. Ажлын байр нь хадгалагдаж буй багш, ажилтны орон тоонд түр ажиллаж байсан багш, ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон тохиолдолд энэхүү журмын 4.1-д заасан тэтгэмж олгохгүй.
- 4.5. Багш, ажилтныг эрэгтэй 60, эмэгтэй 55 нас хүрэхэд нэг удаа 300,000 (гурван зуун мянган) төгрөгийн зардал төсөвлөж, хүндэтгэл үзүүлнэ

ТАВ. БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ОЛГОХ

- 5.1. Тус сургуулийн багш, ажилтанд дараах тохиолдолд буцалтгүй тусламж олгоно. Үүнд:
- 5.1.1. Одоо ажиллаж байгаа багш, ажилтан нас барсан тохиолдолд нэг сарын үндсэн цалинтай тэнцэхүйц мөнгийг буцалтгүй тусламж болгон ар гэрт нь олгоно.

ШУТИС-ийн харьяа Технологийн коллежийн Захирлын 2026 оны
...06 дугаар сарын 05 -ны өдрийн ХХХ дүгээр тушаалын хавсралт



- 5.1.2. Одоо ажиллаж байгаа багш, ажилтны гэр бүлийн гишүүн (эхнэр, нөхөр, эцэг эх, хүүхэд, төрсөн ах, эгч дүү) нас барсан тохиолдолд 500.000 (таван зуун мянган) төгрөгийн буцалтгүй тусламж олгоно.
- 5.1.3. Одоо ажиллаж байгаа багш, ажилтан нь гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл (гал, усны үер, газар хөдлөл, салхи шуурга гэх мэт)-ийн улмаас хохирсон тохиолдолд нэг сарын үндсэн цалинтай тэнцэхүйц төгрөгийн буцалтгүй тусламж олгоно.
- 5.1.4. ШУТИС-д 15-аас дээш жил үр бүтээлтэй ажилласан багш, ажилтан нь хүнд өвчний (эмнэл зүйн, лабораторийн аргаар мэргэжлийн байгууллагаар тодорхойлсон дүгнэлт) улмаас гадаад болон дотоодод 10 сая төгрөгөөс дээш төлбөртэй эмчилгээ хийлгэх тохиолдолд Захирлын зөвлөлийн хурлын шийдвэрээр 2 сая төгрөгийн буцалтгүй тусламж нэг удаа олгоно.
- 5.1.5. Тус сургуульд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон багш, ажилтан нас барсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх мөнгийг буцалтгүй тусламж болгон ар гэрт нь олгоно.

ЗУРГАА. СУРГАЛТЫН ТӨЛБӨРӨӨС ХӨНГӨХ

- 6.1. ШУТИС-д 5-аас дээш жил ажилласан багш, ажилтан нь бакалавр, магистрантур, докторантурт суралцаж буй тохиолдолд нэг хүнд нэг хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 50 хүртэл хувьд тэнцэх хэмжээний мөнгөн дүнг Захирлын зөвлөлийн хурлын шийдвэрээр нэг удаа олгоно.
- 6.2. Багш, ажилтны хүүхэд нь ШУТИС-ийн харьяа Технологийн коллежид суралцдаг бол сургалтын төлбөрөөс жил бүр Хүснэгт 3-т үзүүлсэний дагуу хөнгөлнө.

Хүснэгт 3

Ажилласан хугацаа (жилээр)	Хөнгөлөх хэмжээ (хувиар)
1–3 жил	20%
3–5 жил	30%
5 ба түүнээс дээш	50%

ДОЛОО. САНХҮҮЖИЛТ

- 7.1. Хөнгөлөлтийн зардлыг сургуулийн дотоод санхүүгийн эх үүсвэрээс санхүүжүүлнэ.
- 7.2. Жил бүрийн төсөвт хөнгөлөлтийн зардлыг тусгана.

НАЙМ. БУСАД

- 8.1. Энэхүү журмыг сургуулийн захирлын тушаалаар баталж мөрдөнө.
- 8.2. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.

-----oOo-----